



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/659

Мөрөн сум

Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5, 14 дүгээр зүйлийн 14.7, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 94 дүгээр зүйлийн 94.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох (1) аж ахуйн нэгжийн нэр, талбайн хэмжээ, байршил, солбицол, тусгай зөвшөөрлийн хугацааг хавсралт ёсоор баталсугай.

2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, (П.Мөнхжаргал), Мөрөн сумын Засаг дарга (Х.Тайванбаяр) нарт даалгасугай.


3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын талбайг аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгаж ажиллахыг аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар (Б.Ганзориг) -т даалгасугай.

4. Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг аймаг орон нутгийн орлогод төвлөрүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа)-т үүрэг болгосугай.

5. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.


ДАРГА



П.ЛХАГВАЖАВ



Аймгийн Засаг даргын 2023  
оны 12 дугаар сарын 20-ны өдрийн  
А/..... дугаар захирамжийн хавсралт



ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН АШИГЛАЛТЫН ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН ТАЛБАЙ, СОЛБИЦОЛ, ХУГАЦАА

№	Аж ахуйн нэгжийн нэр	Сум, талбайн нэр	Талбайн хэмжээ га	Хугацаа		Солбицол	
				Эхлэх	Дуусах	Уртраг	Өргөрөг
1	Мөрөн бетон ХХК	Мөрөн сум Их элстэй	51,3	2023 оны 12 сарын 20	2038 оны 12 сарын 20	100 12 57.46 100 12 57.46 100 12 35.37 100 12 35.37	49 36 10.88 49 35 33.43 49 35 33.43 49 36 10.88

ооо